



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 33

Мандалговь

Б.Ууганбатыг Татварын хэлтсийн Луус  
сумын татварын улсын байцаагчийн  
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Татварын хэлтсийн Луус сумын татварын улсын байцаагчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Билгээ овогтой Ууганбат 65.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Б.Ууганбатын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



**Татварын хэлтсийн Луус сумын Татварын улсын  
байцаагчийн албан тушаалд нэр дэвшүүлсэн  
Б.Ууганбатын тухай дүгнэлт**

1. Б.Ууганбат нь 1991 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 31 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2009-2011 онд ХААИС-ЭЗБС-ийг нягтлан бодох бүртгэл мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2014 онд Гурвансайхан сумын ЗДТГ-т дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, 2015-2016 онд Говь-Угтаал сумын Төрийн банканд теллер, 2019-2021 онд Татварын хэлтсийн Сайхан-Овоо сум хариуцсан татвар хураагч, 2021 оноос Луус сум хариуцсан татвар хураагчаар ажиллаж байна.
4. Б.Ууганбатын төрийн албанд ажилласан дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Татварын хэлтсийн Луус сумын татварын улсын байцаагчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ

